

**“АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО” ХХК-ИЙН**

**2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот**

**2017 оны 3-р сар**

## **Агуулга**

1. КОМПАНИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА
  - 1.1 Компанийн эрхэм зорилго, зорилт, эрхэмлэх зарчмууд
  - 1.2 Компаний товч танилцуулга
  - 1.3 Компанийн өнөөгийн бүтэц зохион байгуулалт
  - 1.4 Хууль эрх зүй
2. ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА
  - 2.1 Төлбөр тооцооны үйл ажиллагааны тойм
  - 2.2 Арилжааны шимтгэл
  - 2.3 Гадаад дотоод хөрөнгө оруулагчид
  - 2.4 2016 оны орлогын гүйцэтгэл
3. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ, ПРОГРАМ ХАНГАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
  - 3.1 Компанид ашиглагдаж буй систем
  - 3.2 Мэдээллийн аюулгүй байдал, техник хангамж
4. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА
5. ДОТООД ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
  - 5.1 Ерөнхий мэдээлэл, арга зүй
  - 5.2 Хамарсан хүрээ
6. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 1. КОМПАНИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Компанийн эрхэм зорилго, зорилт, эрхэмлэх зарчмууд

#### ***Компанийн эрхэм зорилго***

Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн нэгэн гол хэсэг бүрэлдэхүүний хувьд, үнэт цаасны арилжааны дараах клиринг, төлбөр тооцоог шуурхай, найдвартай, тасралтгүй гүйцэтгэж, олон улсын жишигт нийцсэн үйлчилгээг үзүүлэх нь “Арилжааны төлбөр тооцоо” ХХК-ний эрхэм зорилго болно.

#### ***Компанийн эрхэм зорилт***

- Үнэт цаасны арилжааны дараах төлбөр тооцоог олон улсын стандартад нийцүүлэн найдвартай гүйцэтгэж, харилцагч байгууллагуудад шуурхай, чирэгдэлгүйгээр үйлчлэх, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн үйлчилгээг сайжруулан, байнгын шинэчлэл хийхийг эрмэлзэх
- Компанийн үйл ажиллагаанд учирч болох зах зээлийн, төлбөрийн чадварын, үйл ажиллагааны, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, харилцагчийн зэрэг эрсдэлийг тооцоолох, үнэлэх, эрсдлээс урьдчилан сэргийлэх зэрэг эрсдлийн удирдлагын цогц системийг бий болгон, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх
- Компанийн техникийн хангамж, цахим сүлжээний аюулгүй байдал, мэдээллийн нууцлал, түүний аюулгүй байдал, цахим сангуудын техникийн аюулгүй ажиллагааг хангаж, олон улсын түвшинд хүргэн, системийн хөгжүүлэлтийг нэн тэргүүнд тавьж ажиллана
- Компанийн үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэн, ашигтай ажиллагааны түвшинг нэмэгдүүлэн, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг арвижуулахын төлөө ажиллах

#### ***Компанийн эрхэмлэх зарчмууд***

Шударга ёс – Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаанд шударга, шуурхай, мэргэжлийн, ил тод байх зарчмыг баримтална.

Найдвартай байдал – Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж харилцагчдыг үнэн зөв мэдээллээр хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх зарчмыг баримтална.

Хариуцлага хүлээх - Монгол улсын хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох журмуудыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, хариуцлага хүлээх зарчмыг баримтална.

Өсөн дэвжих зарчим - Үндсэн үйл ажиллагаандаа байнга шинийг эрэлхийлэх, эдийн засаг санхүү, программ хангамж, удирдлага зохион байгуулалт, боловсон хүчний хувьд байнга өсөн дэвжих зарчмыг баримтална.

## 1.2 Компаний товч танилцуулга

Монгол улсын Засгийн газрын 2015 оны 04-р сарын 17-ны өдрийн тогтоол Үнэт цаас, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд Сангийн сайдын 2015 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн №280 дугаар тушаал, Сангийн сайдын 2016 оны 04-р сарын 13-ны өдрийн 138, 139 дүгээр тушаалын дагуу “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн өөрчлөн зохион байгуулж, арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэх чиг үүрэг бүхий зуун хувь төрийн өмчит “Арилжааны төлбөр тооцоо” ХХК-ийг үүсгэн байгуулсан.

Өмчийн хэлбэр: 100% төрийн өмчтэй, Хязгаарлагдмал хариуцлагатай компани (Төрийн өмчийн төлөөллийг Сангийн яамнаас баталсан Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

Дүрмийн сангийн хэмжээ: 950,893,520.75 төгрөг

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011596045

Регистрийн дугаар: 6051804

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Самбуугийн гудамж 16/1

Утас: 70110104, 70113672

Үнэт цаасны арилжааны дүнд үүссэн төлбөрийг тодорхойлж, тооцоо хийх үйлчилгээг гэрээний үндсэн дээр эрхлэн гүйцэтгэх, арилжаанд оролцогчдын үнэт цаас болон мөнгөн төлбөрийн даалгаврыг холбогдох байгууллагууд руу илгээх зарчмаар баталгаажуулалтыг хийдэг.

Байгууллагын тооцооны үйл ажиллагааг схемээр харуулбал:



### 1.3 Компанийн өнөөгийн бүтэц зохион байгуулалт

Байгууллагын өнөөгийн бүтэц зохион байгуулалтыг схемээр харуулбал:



Өнөөгийн байдлаар “Арилжааны төлбөр тооцоо” ХХК нь 4 албатай, нийт 14 ажилтантай ажиллаж байна. Үүнд:

1. Захиргаа санхүүгийн алба (ЗСА)
2. Үнэт цаасны тооцооны алба (ҮЦТА)
3. Эрсдлийн удирдлагын алба (ЭУА)
4. Мэдээлэл технологийн алба (МТА)

Компанийн хүний нөөцийг мэргэжлээр нь ангилан авч үзвэл:

Хуульч, эрх зүйч	3
Эдийн засагч	4
Нягтлан бодогч	2
Программ хангамжийн инженер	2
Банкны удирдлага	1
Бизнесийн удирдлага, хятад хэл	1
Төрийн захиргааны удирдлага	1
Дээд боловсрол эзэмшсэн	100 хувь
Магистрийн цолтой	3
Гадаад хэлний мэдлэгтэй боловсон хүчний тоо:	
Англи	3
Орос хэл	2
Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхтэй	8
Хөрөнгийн зах зээлийн сургалтанд хамрагдсан	3

Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах АЗ сертификат бүхий эрхтэй	5
Компанийн засаглалын сургалтанд хамрагдсан	5
Архив албан хэрэг хөтлөлтийн сургалт	1
Microsoft Windows Server 2012 Administration сертификаттай	1

#### **1.4 Хууль эрх зүй**

Компанийн хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг Сангийн яам хэрэгжүүлэх бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг тус яамнаас томилдог ба анх Сангийн сайдын 2015 оны 284 дүгээр тогтоолоор компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилж, Сангийн сайдын 2016 оны 175 дугаар тушаал, 2016 оны 423 дүгээр тушаалаар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг өөрчлөн дахин шинээр томилсон. Тушаалын дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг томилсон байна.

Өөрийн үйл ажиллагааг зохицуулсан компанийн дүрмээ Сангийн сайдын 2016 оны 423 дүгээр тушаалын хавсралтаар батлуулж мөрдөн ажиллаж байгаа бөгөөд дотоод үйл ажиллагаа зохицуулсан журамаа гүйцэтгэх захирлын тушаалаар баталж, үндсэн үйл ажиллагаа зохицуулах журмыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулсан.

## 2. ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1 Төлбөр тооцооны үйл ажиллагааны тойм

Тус компани нь төлбөрийг харилцан суутгаж эцсийн үлдэгдлийг гаргахын тулд төлбөрийн даалгаврыг дамжуулах, тооцоо нийлэх, зарим тохиолдолд тооцоо хийхээс өмнө төлбөрийн даалгаврыг баталгаажуулах бөгөөд үнэт цаасны төлбөр тооцоог гүйцэтгэх зэрэг зуучлалын үйлчилгээнүүдийг зах зээлд санал болгож байна.

### 2016 онд “Арилжааны төлбөр тооцоо” ХХК-аар хийгдсэн мөнгөн хөрөнгийн гүйлгээ

*2016 оны 04 сарын 18-ны өдрөөс 12 сарын 28-ны өдрийг хүртэл хугацаанд*

Гүйлгээ хийгдсэн банк	Гүйлгээний төрөл	Харилцагч тоо	Нийт гүйлгээ		Их дүнтэй гүйлгээ, ш		Бага дүнтэй гүйлгээ, ш	
			Гүйлгээ, ш.	Үнийн дүн /мян.төг/	Гүйлгээ, ш.	Үнийн дүн /мян.төг/	Гүйлгээ, ш.	Үнийн дүн /мян.төг/
АТТ банк	Орлогын гүйлгээ		924	859,278,752.2	660	859,183,166.4	264	95,585.80
	Зарлагын гүйлгээ		756	859,188,206.7	432	859,119,607.5	324	68,599.20
Төрийн банк	Орлогын гүйлгээ		35	178	-	-	-	-
	Зарлагын гүйлгээ		24	114.8	-	-	-	-
Нийт гүйлгээ	Орлогын гүйлгээ	311	959	859,278,930.2	660	859,183,166.4	264	95,585.80
	Зарлагын гүйлгээ	128	780	859,188,321.5	432	859,119,607.5	324	68,599.20
Бүгд		439	1,739	1,718,467,251.7	1,092	1,718,302,773.9	588	164,185.00
<b>Данс хооронд хийгдсэн гүйлгээ</b>			1,149	524,000,000.0				

### 2016 онд төлбөр гүйцэтгэх банкуудаар хийж гүйцэтгэсэн гүйлгээ (сая төгрөг)

*2016 оны 04 сарын 18-ны өдрөөс 12 сарын 28-ны өдрийг хүртэл хугацаанд*

Д / д	Банк	Дүн
1	Голомт банк	4,890.0
2	ХХБ	4,486.3
3	Хас банк	7,431.8
4	ХААН банк	739.3
	<b>Нийт</b>	<b>17,547.4</b>

Засгийн газрын үнэт цаасны үндсэн ба хүүгийн төлбөрийг 2016 оны 09 дүгээр сарын 19-ны өдрөөс “ҮЦТХТ” ХХК-иас шилжүүлэн авч гүйцэтгэж байна. Монголбанкаар арилжаалагдсан Засгийн газрын үнэт цаасны 574,345,612,328.75 төгрөгийн үндсэн ба хүүгийн төлбөр, Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдсан Засгийн газрын үнэт цаасны 55,933,615,789.03 төгрөгийн үндсэн ба хүүгийн төлбөр, нийт 630,279,228,117.78 төгрөгийн төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн.

2016 онд МХБ-ээр 244 удаагийн арилжаа явагдаж 14,857 хэлцлээр нийт 348,6 тэрбум төгрөгийн үнэ бүхий 96,959,669 ширхэг үнэт цаас арилжигдсан. Үүнээс 299,6 тэрбум төгрөгийн 3,250,124 ширхэг Засгийн газрын үнэт цаас арилжигдсан байна.

## 2.2 Арилжааны шимтгэл

АТТ ХХК нь 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс өөрийн болон үнэт цаасны зах зээлд оролцогч бусад байгууллагын шимтгэл хураамжийн тооцоог хийж, холбогдох байгууллагуудад хуваарилан төлбөр тооцоог гүйцэтгэсэн.

Үнэт цаасны зах зээл дэх үйлчилгээний хөлсний хэмжээ /Хавсралт 1 –г харна уу/ -г судлахад дараахь дүгнэлтэнд хүрч байна. Үүнд:

1. Шимтгэлийн хувь хэмжээ нь оролцогч байгууллагуудын хувьд харьцангуй адилгүй бөгөөд зах зээлд гүйцэтгэх үүрэг, оруулдаг хувь нэмрийг үндэслэн бодитоогоор тогтоож өгөх шаардлагтай байна
2. Цаашдаа зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн гарах тохиолдолд шимтгэлийн хувь хэмжээг олон улсын ижил төстэй байгууллагуудын туршлагыг судалж, клиринг, төлбөр тооцооны байгууллагыг дэмжин хөгжүүлэх үүднээс зах зээлийн үнэлгээ, бодит хувь нэмрийг нь үнэлж тогтоох шаардлагтай байна
3. Зохицуулах эрх бүхий байгууллагын шимтгэлийн хувь хэмжээ нь арилжааны үнийн дүнгээс уян хатан /үнийн дүнгээс хамаарч буурах шатлалаар/ тогтоож өгөх.


2016.04.18 - 2016.12.28 хооронд 277,3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж нийт 726,3 сая төгрөгийн шимтгэл тооцогдсон байна.

*Жич:* Нийт шимтгэлийн дүнд ҮЦК-иудын хувьд зөвхөн засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанаас тооцогдсон шимтгэлийн дүн орсон.

### Арилжааны шимтгэлийн үзүүлэлт (мян. төг)

Хугацаа	МХБ	АТТ	СЗХ	БДК	Нийт
2016 оны 04.18-12.28-ны байдлаарх	478,177.1	192,031.1	-	56,168.8	726,377.0

**АРИЛЖААНЫ ШИМТГЭЛИЙН ДҮНД  
МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ  
/2016.04.18-12.28/**






### 2.3 Гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны үнийн дүнд эзлэх хувь

2016 онд арилжааны үнийн дүнд гадаадын аж ахуйн нэгж болон иргэдийн эзлэх хувь 2,39 %-тай байгаа бол дотоодын аж ахуйн нэгж болон дотоодын иргэдийн эзлэх хувь 97,61 %-тай байна.

ГАДААД, ДОТООД ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН  
АРИЛЖААНЫ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ/2016.04.18-12.28/



### 2.4 АТТ ХХК –ийн орлогын хураангуй

2016 онд нийт 192,1 сая төгрөгийн орлоготой, төлбөр тооцооны орлогын төлөвлөгөө 69,5%-ийн биелэлттэй байна.

/мян. төг/

Орлогын утга	2016 оны төсөв	2016 оны гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
Хувьцааны арилжааны шимтгэл	264,981.0	178,826.6	67.5%
ЗГ-ын өрийн бичгийн шимтгэл /анхдагч/	6,613.7	13,204.5	199.6%
Компанийн бондын арилжааны шимтгэл	5,000.0	-	-
Бусад орлого / монгол банкаар хийгдсэн гүйлгээний шимтгэл/	-	142.8	+
<b>Төлбөр тооцооны орлогын дүн</b>	<b>276.594.7</b>	<b>192,173.9</b>	<b>69.5%</b>

### **3. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ, ПРОГРАМ ХАНГАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

#### **3.1 Компанид ашиглагдаж буй систем**

Монгол улсын Сангийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 13-ны 138 дугаар тушаалын дагуу компани хуваагдаж ҮЦТТТХТ ХХК-д ашиглагдаж байсан E-Clearing House системийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д шилжүүлсэн учир хоёр компанийн хооронд 2016.04.18-ны №16/04/02 тоот актын дагуу харилцан адил эрхтэйгээр E-Clearing House системийг эзэмшиж, ашиглахаар харилцан тохиролцны үндсэн дээр ашиглаж байна.

Мөн ҮЦТТТХТ ХХК-ийн мэдээллийн сангаас АТТ ХХК-д ашиглаж мэдээллийг хүлээн авч 2016.04.18-ны өдөр акт үйлдэж хоёр компанийн удирдлагаар батгаажуулсан. Энэхүү мэдээлэлд зөвхөн харилцагчдын данс /bridge-948890 бичлэг/ болон харилцагчийн мэдээлэл /holders-795613 бичлэг/-г хүлээн авсан бөгөөд дээрхи дансны мэдээлэл нь зөвхөн анхдагч зах зээлд оролцогчдын хувьцааны төлбөрийг байршуулахад ашиглахаар хүлээн авсан болно.

Манай компанийн үндсэн үйл ажиллагааны дагуу компани үүсгэн байгуулагдахаас өмнөх шаардлагатай мэдээллийн сан /арилжааны мэдээ, итгэмжлэл, захиран зарцуулагч, гарын үсгийн баталгаа/ -г 2016.07.01 –ний өдрийн актын дагуу хүлээн авсан болно.

Мөн банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцооны системийн time-out хугацааг багасган буцаалтын гүйлгээг дэмждэг болгох системийн өөрчлөлтийг Монгол банкны Үндэсний цахим гүйлгээний төвтэй хамтран туршиж нэвтрүүлсэн.

#### **3.1.1 E-Clearing House систем**

- Арилжааны төлбөр тооцооны шимтгэлийн данс, Монгол банкны данснаас бусад дансны хувьд Монгол банкны гүйлгээний шимтгэл тооцдог байх програмын өөрчлөлтийг оруулсан.
- Монгол банкны банк хоорондын төлбөрийн системд 1 сая төгрөгийг их дүнтэй гүйлгээнд оруулдаг байсныг 2016 оны 07 сарын 1 –ээс хойш бага дүнтэй гүйлгээнд оруулах тухай шийдвэрийн дагуу холбогдох системийн өөчлөлтүүдийг хийсэн.
- Засгийн газрын бондын шимтгэлийг данс хоорондын шилжүүлгээс шүүж гаргадаг байсныг холбогдох тайлан судалгаа боловсруулан Хяналт судалгаа, Төлбөр тооцооны дэд системүүдэд холбосон.
- Мөнгөн хөрөнгийн дэд системийн Зарлагын гүйлгээний жагсаалтанд шилжүүлэгч болон хүлээн авагч банкийг гаргадаг байхаар холбогдох системийн өөрчлөлтийг оруулсан.

- Гүйцэтгэх захирлын 2016 оны 09 дүгээр сарын 30-ны А/032 тоот тушаалын дагуу бэлэн мөнгөний төрөл нэгтгэсэнтэй холбоотой холбогдох системийн өөрчлөлтүүдийг хийсэн. /Төлбөр тооцооны болон банк хоорондын их болон бага дүнтэй төлбөр тооцооны системүүдэд/
- Монгол банкны бага дүнтэй төлбөр тооцооны системд буцаалтын гүйлгээ хийх боломжтой болгон холбогдох өөрчлөлтийг Монгол банктай туршиж баталгаажуулсан.

### **3.1.2 Миллениум Ай Ти Си Эс Ди системтэй холбоотой хийгдсэн ажил**

Сангийн сайдын тушаалын дагуу 2016 оны 04 сарын 18 –аас компани хуваагдахдаа CSD систем нэвтрэх эрхийг “ҮЦТХТ” ХХК –иас авч ажиллаж байгаа болно. Энэхүү систем нь ТӨХ болон Лондонгийн хөрөнгийн бирж, МХБ-ийн гэрээний дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд суурилагдсан систем учир манай кампани нь СиЭсДи системийг зөвхөн арилжааны мэдээлэл татаж авах болон төлбөр тооцооны мэдээллийн харах хэрэглэгчийн эрхтэйгээр ашиглаж байгаа болно.

### **3.2 Мэдээллийн аюулгүй байдал, техник хангамж**

Компани хуваагдахдаа ҮЦТТХТ ХХК-иас дараах техник, тоног төхөөрөмжийг хүлээн авч үйл ажилгаандаа ашиглаж байна. Үүнд:

<b>№</b>	<b>Техник, тоног төхөөрөмжийн төрөл</b>	<b>Техникийн үзүүлэлт</b>	<b>Тоо ширхэг</b>
1	Компьютер	B/6320/2GB/500GB/DVD-RW/256MB GRA/SPEAKER/19LCD	12
2	Сервер	DELL POWEREDGE R720 CEPBER 16GB RAM 2*300GB 15KRPM	2
3	Сервер	DELL POWEREDGE R220 CEPBER 8GB RAM 2*500GB HDD	5
4	Managed switch	Managed switch	2
5	Unmanaged switch	Unmanaged switch	2
6	Принтер	HP laserjet 1102	7
7	Тог баригч	3KVA	4

- Байгууллагын нөөц төвийг байгуулах бэлтгэл ажлыг ханган 3 серверт холбогдох үйлдлийн системийн суурилуулалтыг хийж гүйцэтгэж, үндэсний дата төвөөс байршуулах тоног төхөөрөмжийн үнэлгээг гаргуулж авсан.
- Онцгой тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөө гаргаж Гүйцэтгэх захирлаар батлуулсан.

#### **4. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА**

Төрийн банк дахь Төлбөрийн баталгааны сангийн үлдэгдэл хөрөнгийн бүртгэлийг хөтлөж, хяналт тавьж ажилласан.

“Тооцооны байгууллагын гишүүдийн төлбөрийн чадварын эрсдлийг удирдах, зохицуулах журам”-ыг боловруулсан. Эрсдлийн сангийн журам болон төлбөрийн баталгааны сангийн журам тус тус боловсруулахаар судалгаа хийж ажилласан.

Олон улсын төлбөр тооцооны байгууллагуудыг судалгааны ажил хийсэн. Жишээ нь:

- Японы тооцооны байгууллагын төлбөр тооцооны шимтгэл болон барьцаа хөрөнгө байршуулах үйл ажиллагааны талаар судалгаа
- Насдак-Клирингийн Тооцооны гишүүнтэй байгуулах гэрээ

## **5. ДОТООД ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **5.1 Ерөнхий мэдээлэл, арга зүй**

Дотоод хяналтыг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт болох Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх горим аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Арилжааны төлбөр тооцоо ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлаар улирал бүрийн шалгалтын удирдамжийг батлуулан ТТА, ЗСА, ЭУА-ны хүрээнд 7 удаа, гэнэтийн шалгалтыг 2 удаа нийт 9 удаа дотоод хяналтын шалгалтыг зохион байгууллаа.

### **5.2 Хамарсан хүрээ**

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт журамд Аж ахуй нэгж байгууллага нь журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журамтай байна, дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ Арилжааны төлбөр тооцоо ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал баталсан дотоод хяналтын журамд заасан чиглэлээр санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаанд тавих хяналт, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд тавих хяналт, эрсдлийн удирдлагын албаны сангийн бүртгэл тооцоог хөтлөх хяналт, харилцагчийн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх зэргийг хамруулсан болно.

Дотоод хяналтыг Төлбөр тооцооны албаны тухайд хяналтын хугацаанд хамаарах гүйлгээний баримтуудаас түүвэрлэн, ажлын хүснэгт, тусгай журнал, ерөнхий журнал болон бусад анхан шатны баримтуудыг авч шалгасан. Захиргаа санхүүгийн албаны шалгалтыг касс харилцахын баримтууд, дэлгэрэнгүй болон ерөнхий журнал, тайлан баланс кассын тооллогын үлдэгдлийг тулган шалгасан ба үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын бүртгэлээс түүвэрлэн авч шалгаж үзлээ. Мөн жилийн худалдан авалтын баримтын бүрдэл, гүйцэтгэх захирлын тушаалын биелэлт, ирсэн явсан бичгийн бүртгэл хөтлөлтөнд шалгалт хийсэн. Эрсдлийн удирдлагын албаны тухайд ҮЦК-ийн байршуулсан барьцаа хөрөнгө болон төлбөрийн баталгааны сангийн үлдэгдэл тооцогдсон хүү зэргийн бүртгэл хөтлөлтийг хянан шалгаж үзлээ.

## 6. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Захиргаа санхүүгийн албаны ажил үүргийн хуваарийн дагуу 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сүхбаатар дүүргийн татварын хэлтэс, Улсын төсвийн орлого хяналтын газар, Сүхбаатар дүүргийн төрийн сангийн хэлтэс, Сангийн яамны төсөвт байгууллагын сайт руу тус тус шивж оруулсан.

2016 оны байдлаар арилжааны шимтгэлийн нийт орлого 192,168,265.22 төгрөг харилцахын хүүгийн орлого 9,435,688.52 төгрөг нийт 201,603,853.74 төгрөг, үйл ажиллагааны зардал 240,227,592.55 төгрөг тайлант үеийн ашиг /алдагдал/ /50,284,427.16/ төгрөг болсон байна.

### "АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО" ХХК САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31 өдөр

*(төгрөгөөр)*

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 ОНЫ 04-Р САРЫН 28	2016 ОНЫ 12-Р САРЫН 31
А	Б	1	2
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	886,331,652.14	924,678,984.87
1.1.2	Дансны авлага		-
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	1,060,090.00	5,872,080.50
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	118,229.96
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>887,391,742.14</b>	<b>930,669,295.33</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
<b>1.2.1</b>	<b>Үндсэн хөрөнгө</b>	<b>63,501,778.61</b>	<b>61,993,542.03</b>
1.2.2	Биет бус хөрөнгө		1,875,103.20
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		26,405.25
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		60,092,033.59
1.2.9	Дуусаагүй барилга	-	

*“Арилжааны төлбөр тооцоо” ХХК*

<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>63,501,778.61</b>	<b>61,993,542.04</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>950,893,520.75</b>	<b>992,662,837.37</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг		-
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр		997,118.11
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат өглөг		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		91,056,625.66
2.1.1.15	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>92,053,743.77</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>-</b>	<b>92,053,743.77</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч : - төрийн	950,893,520.75	950,893,520.75
2.3.2	- хувийн	-	
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-	- 50,284,427.16
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>950,893,520.75</b>	<b>900,609,093.60</b>
<b>2.3.20</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>950,893,520.75</b>	<b>992,662,837.37</b>

## “Арилжааны төлбөр тооцоо” ХХК

Байгууллагын тасралтгүй хэвийн үйл ажиллагааг явуулахын тулд тодорхой тооны тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, хангамжийн материал, бичиг хэргийн материал зэргийг худалдан авсан.

2016 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр **11,185,948.00** /арван нэгэн сая нэг зуун наян таван мянга есөн зуун дөчин найм/ төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авалт хийсний 7,465,500,00 /долоон сая дөрвөн зуун жаран таван мянга таван зуу/ төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, 3,720,448.00 /Гурван сая долоон зуун хорин мянга дөрвөн зуун дөчин найм/ төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан байна. Үндсэн хөрөнгийн худалдан авалтыг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа болон ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нийлүүлэгч байгууллага тус бүртэй гэрээ байгуулан нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг бүрдлийг хангаж ажилласан.

Жилийн эцсийн байдлаар гарсан зардлын задаргааг өссөн дүнгээр тоймлон авч үзвэл дараах байдалтай байна.

/мян.төг/

№	Зардлын төрөл	Зардлын дүн	Нийт зардалд эзлэх хувь хэмжээ
1	Цалин ТУЗ	19,500.0	8,1%
2	ТУЗ 10,8%	2,106.0	0,8%
3	Цалин ажилчид	156,811.2	60,9%
4	НДШ 11%	17,205.8	7,1%
5	Шуудан холбооны зардал	1,709.9	0,7%
6	Ашиглалтын зардал	4,134.2	1,7%
7	Түрээсийн зардал	14,400.0	5,9%
8	Шатахууны зардал	2,045.0	0,8%
9	Үндсэн хөрөнг худалдан авалтын зардал	11,185.9	4,6%
11	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	12,720.0	5,2%
12	Бусад зардал	8,803.5	3,6%
	<b>Нийт дүн</b>	<b>240,227.5</b>	<b>100%</b>